ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Сантмаргац сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/156/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn
Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн
Утас: 99014227
Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
   - 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
   - 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
   - 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
   - 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
   - 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга 8
   - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
   - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
   - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
   - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан 13
   - 4.1 Ерөнхий зүйл 13
   - 4.2 Материаллаг байдал 14
   - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт 14
   - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 14
   - 4.5 Засрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 15
   - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 16
5. Аудитын илрүүлэлт 16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.21 № 193

танай ______ -ны № ______ -т

САНТМАРГАЦ СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ц.НАМЖИЛДУЛАМ-Д

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сантмаргац сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сантмаргац сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сантмаргац сумын Хүүхдийн цэцэрлэгт Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 14,185.6 мянган төгрөгийн зөөврийн компьютер, Орон нутгийн хөгжлийн сангаас 2,500.0 мянган төгрөгийн цахилгаан мотор, бусад эх үүсвэрээс 2,389.8 мянган төгрөгийн зурагт, тоос сорогч нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Сантмаргац сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар нягтлан бодогч балансын урамшууллыг эрхлэгчийн тушаалаас 2 сараар илүү тооцож авсан,албан томилолтын зардлыг сургуулийн захирлын зөвшөөрлөөр хүүхдийн цэцэрлэгээс олгосон, газрын үнэлгээг дансанд 1,205.1 мянган төгрөгөөр дутуу тусгасан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг акталж устгах, дахин үнэлүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Сантмаргац сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 50 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 95.6 хувьтай үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**



8 [illegible] 2025

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| ДАНС | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 118,434,855.77 | 181,979,339.90 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 49,975,401.77 | 108,539,773.07 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 49,975,401.77 | 108,539,773.07 |
| 3121 | Төгрөг | 49,975,401.77 | 108,539,773.07 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 49,975,401.77 | 108,539,773.07 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 0.00 | - |
| 33 | АВЛАГА | 2,000.00 | 3,174,492.83 |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 2,000.00 | 3,174,492.83 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 68,457,454.00 | 70,265,074.00 |
| 351 | Түүхий эд материал | 9,173,800.00 | 9,371,300.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 7,822,800.00 | 7,822,800.00 |
| 35130 | Эм боох материал | 1,351,000.00 | 1,548,500.00 |
| 354 | Хангамжийн материал | 59,283,654.00 | 60,893,774.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 245,000.00 | 245,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 12,014,300.00 | 12,631,800.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 726,500.00 | 726,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 10,703,180.00 | 6,695,800.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 35,594,674.00 | 40,594,674.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 624,315,238.84 | 624,912,884.88 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 624,315,238.84 | 624,912,884.88 |
| 392 | Биет хөрөнгө | 616,610,738.84 | 617,538,384.88 |
| 39201 | Барилга, байгууламж | 629,163,100.00 | 629,163,100.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (54,863,287.68) | (69,749,790.24) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 60,367,244.00 | 83,916,644.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (27,027,641.97) | (34,599,494.05) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 13,828,009.00 | 14,606,009.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (12,402,197.22) | (12,680,846.50) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 8,197,500.00 | 8,197,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,846,145.85) | (2,508,895.89) |
| 39217 | Номын фонд | 1,194,158.56 | 1,194,158.56 |
| 393 | Биет бус хөрөнгө | 7,704,500.00 | 7,374,500.00 |
| 39301 | Програм хангамж | 1,650,000.00 | 1,650,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (1,182,500.00) | (1,512,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,237,000.00 | 7,237,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 742,750,094.61 | 806,892,224.78 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | (0.00) | 2,039,683.71 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | (0.00) | 2,039,683.71 |
| 413 | Өглөг | (0.00) | 2,039,683.71 |
| 4136 | Бусад өглөг | (0.00) | 2,039,683.71 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | (0.00) | 2,039,683.71 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 742,750,094.61 | 804,852,541.07 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 742,750,094.61 | 804,852,541.07 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 392,571,256.80 | 392,571,256.80 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 392,571,256.80 | 392,571,256.80 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 116,376,722.13 | 178,479,168.59 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 116,376,722.13 | 116,376,722.13 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 62,102,446.46 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 233,802,115.68 | 233,802,115.68 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 742,750,094.61 | 806,892,224.78 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| ДАНС | ITEM NAME | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 449,665,154.16 | 602,335,600.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 21,647,395.00 | 24,327,400.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 21,647,395.00 | 24,327,400.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 21,647,395.00 | 24,327,400.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 21,647,395.00 | 24,327,400.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 428,017,759.16 | 578,008,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 392,942,200.00 | 538,380,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 392,942,200.00 | 538,380,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 35,076,500.00 | 39,627,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 35,076,500.00 | 39,627,900.00 |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг/орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | (940.84) | - |
| 1330 | Төсвийн захирагчдаас | (940.84) | - |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 404,008,576.24 | 540,233,153.54 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 404,008,576.24 | 540,233,153.54 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 404,008,576.24 | 537,505,298.48 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 264,238,164.98 | 375,386,577.22 |
| 210101 | Цалин | 194,364,188.15 | 259,854,414.11 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 48,451,241.83 | 108,255,478.74 |
| 210104 | Урамшуулал | 21,422,735.00 | 7,276,684.37 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 32,697,829.59 | 47,346,319.65 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 22,296,051.66 | 31,677,272.96 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2,632,344.46 | 4,107,600.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 2,105,875.58 | 2,053,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 494,626.62 | 2,053,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 5,168,931.27 | 7,453,846.69 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 33,075,559.16 | 36,619,730.65 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 3,289,199.16 | 2,803,376.65 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 29,126,360.00 | 33,816,354.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 660,000.00 | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 544,000.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | - | 544,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 39,286,530.00 | 42,640,380.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол | 39,286,530.00 | 42,640,380.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,000,000.00 | 1,999,998.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 1,999,998.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 640,000.00 | 1,300,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 640,000.00 | 1,300,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,070,492.51 | 31,668,292.96 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,714,200.00 | 6,371,639.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 1,229,900.00 | 1,566,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 22,126,392.51 | 23,729,753.96 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 2,727,855.06 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 2,727,855.06 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 2,727,855.06 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 45,656,577.92 | 62,102,446.46 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 45,656,577.92 | 62,102,446.46 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

| ДАНС | ITEM NAME | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 428,017,759.16 | 578,008,200.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 428,017,759.16 | 578,008,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 392,942,200.00 | 538,380,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 392,942,200.00 | 538,380,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 35,075,559.16 | 39,627,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 35,076,500.00 | 39,627,900.00 |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | (940.84) | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 382,193,913.73 | 519,443,828.70 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 382,193,913.73 | 519,443,828.70 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 382,193,913.73 | 516,715,973.64 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 264,238,164.98 | 377,394,423.34 |
| 210101 | Үндсэн цалин | 194,364,188.15 | 259,827,832.70 |
| 210102 | Нэмэгдэл | 48,451,241.83 | 107,340,111.64 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 21,422,735.00 | 10,226,479.00 |
| 2102 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 32,699,829.59 | 48,510,966.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 22,298,051.66 | 32,080,666.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2,632,344.46 | 4,107,600.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 2,105,875.58 | 2,053,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 494,626.62 | 2,053,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 5,168,931.27 | 8,215,100.00 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 33,075,559.16 | 34,900,046.94 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 3,289,199.16 | 2,608,105.44 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 29,126,360.00 | 31,971,941.50 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 660,000.00 | 320,000.00 |
| 2105 | Норматив зардал | 37,318,600.00 | 38,633,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 37,318,600.00 | 38,633,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,000,000.00 | 1,999,998.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 1,999,998.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 640,000.00 | 1,300,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 640,000.00 | 1,300,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,221,760.00 | 13,977,539.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,237,060.00 | 9,510,639.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 1,984,700.00 | 4,466,900.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 2,727,855.06 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 2,727,855.06 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 2,727,855.06 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 45,823,845.43 | 58,564,371.30 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 45,823,845.43 | 58,564,371.30 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 4,151,556.34 | 49,975,401.77 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 49,975,401.77 | 108,539,773.07 |

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| ДАНС | | | | |
| 2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 392,571,256.80 | 233,802,115.68 | 70,720,144.21 | 697,093,516.69 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 392,571,256.80 | 233,802,115.68 | 70,720,144.21 | 697,093,516.69 |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 45,656,577.92 | 45,656,577.92 |
| 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 392,571,256.80 | 233,802,115.68 | 116,376,722.13 | 742,750,094.61 |
| 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 392,571,256.80 | 233,802,115.68 | 116,376,722.13 | 742,750,094.61 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 392,571,256.80 | 233,802,115.68 | 116,376,722.13 | 742,750,094.61 |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 62,102,446.46 | 62,102,446.46 |
| 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 392,571,256.80 | 233,802,115.68 | 178,479,168.59 | 804,852,541.07 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31 /төгрөгөөр/

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 49,975,401.77 |
| **2** | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **627,389,200.00** | **516,715,973.64** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **627,389,200.00** | **516,715,973.64** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **627,389,200.00** | **516,715,973.64** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **468,419,300.00** | **377,394,423.34** |
| 210101 | Үндсэн цалин | 328,493,100.00 | 259,827,832.70 |
| 210102 | Нэмэгдэл | 138,634,900.00 | 107,340,111.64 |
| 210104 | Урамшуулал | 1,291,300.00 | 10,226,479.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **55,005,600.00** | **48,510,966.36** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,404,700.00 | 32,080,666.36 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,399,600.00 | 4,107,600.00 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 2,200,200.00 | 2,053,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,200,200.00 | 2,053,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,800,900.00 | 8,215,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **37,627,900.00** | **34,900,046.94** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 3,289,200.00 | 2,608,105.44 |
| 210302 | Түлш, халаалт | 33,678,700.00 | 31,971,941.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 660,000.00 | 320,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **42,009,300.00** | **38,633,000.00** |
| 210502 | Хоол, хүнс | 42,009,300.00 | 38,633,000.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 2,000,000.00 | 1,999,998.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 1,999,998.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **1,588,300.00** | **1,300,000.00** |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 1,588,300.00 | 1,300,000.00 |
| **2201** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **20,738,800.00** | **13,977,539.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,271,500.00 | 9,510,639.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,467,300.00 | 4,466,900.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **39,627,900.00** | **578,008,200.00** |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | - | 538,380,300.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | - | 538,380,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **39,627,900.00** | **39,627,900.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 39,627,900.00 | 39,627,900.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 49,975,401.77 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 108,539,773.07 |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 17.00 | 17.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 8.00 | 8.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4.00 | 4.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 сарын 31 /төгрөгөөр/

| ДАНС | УЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **39,627,900.00** | **36,900,044.94** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 3,289,200.00 | 2,608,105.44 |
| 210302 | Түлш, халаалт | 33,678,700.00 | 31,971,941.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 660,000.00 | 320,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 1,999,998.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **39,627,900.00** | **39,627,900.00** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 39,627,900.00 | 39,627,900.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Завхан аймгийн Сантмаргац сумын хүүхдийн цэцэрлэгийн чиглэл:***

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

***Завхан аймгийн Сантмаргац сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго:***

Завхан аймгийн Сантмаргац сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 50 арга хэмжээ төлөвлөснөөс 95.6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Завхан аймгийн Сантмаргац сумын хүүхдийн цэцэрлэгийн*** *үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай”, “цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх” зэрэг Засгийн газрын тогоолуудад өөрчлөлт орсон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналт тавин ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Сантмаргац *сумын хүүхдийн цэцэрлэгийн* 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Сантмаргац сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 64,142.1 мянган төгрөгөөр буюу 8.6 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 49,975.4 | 108,539.8 | 58,564.4 |
| Авлага | 2.0 | 3,174.5 | 3,172.5 |
| Бараа материал | 68,457.4 | 70,265.1 | 1,807.7 |
| Үндсэн хөрөнгө | 624,315.2 | 624,912.9 | 597.7 |
| **Нийт хөрөнгө** | **742,750.1** | **806,892.2** | **64,142.1** |
| Өр төлбөрийн дүн | 0 | 2,039.7 | 2,039.7 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 742,750.1 | 804,852.5 | 62,102.4 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **742,750.1** | **806,892.2** | **64,142.1** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайлант онд:**

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 58,564.4 мянган төгрөгөөр, бараа материал 1,807.7 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө 597.7 мянган төгрөгөөр, авлага 3,172.5 мянган төгрөгөөр тус тус өсчээ.

Тус цэцэрлэг нь оны эхэнд 68,457.4 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр 48,921.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч 47,114.3 мянган төгрөгийн зарцуулалт хийснээр 624,912.9 мянган төгрөгийн бараа материалыг тоолж, тооллогын бүртгэл хөтөлж, тооцоог бодсон байна. Үндсэн хөрөнгийн хувьд 24,327.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг хандив тусламжаар орлогот авч бүртгэлд тусгажээ. Тайлант онд 23,729.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Тайлант оны эцэст авлага 3,172.5 мянган төгрөгөөр, өглөг 2,039.7 мянган төгрөгөөр тус тус өсчээ. Өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулсан байна.

**Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай” 82, 128 дугаар тогтоолуудын дагуу ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл нэмэгдэж, төсвийг тодотгосноор тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 587,681.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 39,627.9 мянган төгрөгөөрнийт 627,309.4 мянган төгрөг, зардлыг 627,309.4 мянган төгрөг байхаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн, батлуулж ажилласан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын болон орон нутгийн төсвөөс 578,008.2 мянган төгрөгийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 516,715.9 мянган төгрөг буюу 82.4 хувьтай байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хоолны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бараа үйлчилгээний бусад зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөра рга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсвөөс санхүүжих** | | | | | |
| **71801** | **Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр** | **587,681.5** | **479,815.9** | **108,865.6** | **81.6** |
| 80233 | Хүүхэд хамгааллын зардал | 707.6 | 0 | 707.6 | 0 |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих зардал | 997.5 | 997.5 | 0 | 100 |
| 81807 | Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал | 39,237.3 | 38,633.0 | 604.3 | 98.5 |
| 81816 | Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр | 2,187.5 | 2,100.0 | 87.5 | 96.0 |
| 81823 | Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардал | 1,029.9 | 926.0 | 103.9 | 89.9 |
| 81832 | Нүүдлийн бүлэгт хамруулах | 25,047.0 | 2,544.2 | 22,502.8 | 10.2 |
| 81834 | Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, | 518,474.7 | 434,615.1 | 83,859.6 | 83.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал | | | | |
| **Дүн** | | **587,681.5** | **479,815.9** | **108,865.6** | **81.6** |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| 80109 | Тогтмол зардал | 39,627.9 | 36,900.0 | 2,727.9 | 93.1 |
| **Нийт дүн** | | **627,309.4** | **516,715.9** | **111,593.5** | **82.4** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 39,627.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой зардалд 34,900.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 2,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 2,727.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

**Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

| | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| | Оч дөл өлзийт ХХК шууд гэрээ | Дулаан, халаалт | 33,819.3 | 31,971.9 |
| 2 | АУЭХС шууд гэрээ | Гэрэл цахилгаан | 2,803.4 | 2,608.1 |
| 3 | ААНБ, иргэд шууд гэрээ | Хоол хүнс | 39,237.3 | 38,633.0 |
| **ДҮН** | | | **75,860.0** | **73,213.0** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Завхан аймгийн Сантмаргац сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Үндраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Сантмаргац сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1.5 хувиар тооцож, 2,695.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75.0 хувь буюу 2,021.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завхан аймгийн Сантмаргац сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан тул акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн үед тооцоо бодож, үр дүнг тооцож байх
2. Харилцагч зарим байгууллагаас и баримт шивүүлээгүй, албан томилолтын мөнгийг бүх ажилчдад анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар олгосон байна. Иймд анхан шатны баримтыг үндэслэн зарлагын гүйлгээг хийж байх
3. Хүүхдийн хоолны нормативыг мөрдөж ажиллах, амархан муудаж, чанар байдал нь алдагдах хүнсний бүтээгдэхүүнийг нөөцөлж, удаан хугацаагаар хадгалахгүй байх, эд хариуцагчийн гаргаж байгаа бараа материалын тайланг сар бүр хянаж, үлдэгдлийг баталж байх

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,482.5 мянган төгрөгийн алдаа илэрч, 1,482.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

**5.1 Төлбөрийн акт:** Нягтлан бодогч, эд хариуцагч нар нь цагийн бүртгэлд бичигдээгүй, эрхлэгчийн шийдвэргүйгээр илүү цагийн мөнгө авсан, нягтлан бодогч нь балансын урамшууллыг эрхлэгчийн тушаалаас 2 сараар илүү тооцож авсан, албан томилолтын мөнгийг сургуулийн захирлын зөвшөөрлөөр хүүхдийн цэцэрлэгийн байгууллагаас авсан нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах". Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн байдал:** Төлбөрийн акт тогтоов.

**5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

**5.3 Зөвлөмж:**

1. Тус цэцэрлэгийн 2024 оны тооллогын бүртгэлд газрын хэмжээг 1мкв, нийт үнийг 6.030.9 гэж бүртгэсэн бөгөөд уг газар нь газар эзэмших эрхийн гэрчилгээнд 3618 мкв хэмжээтэй, үнэ нь 7.236.0 төгрөг байна. Биет бус хөрөнгийн данс болон газар эзэмших гэрчилгээнд байгаа хэмжээ зөрүүтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.1.1-д “Үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.-д “Үнэн зөв байх” зэрэг заалтуудтай нийцэхгүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн байдал:** Газрын хэмжээ, үнэлгээг хянаж, бүртгэлд бүрэн тусгах зөвлөмж өгөв.

2. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 42 нэр төрлийн 28,529.1 мянган төгрөгийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байгаа нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 "төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдсэн үндсэн хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шитгэлээрээ анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд

хөрөнгийн үнийг ТӨБЗ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн байдал:** Дээрхи хөрөнгийг акталж устгах, дахин үнэлүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж өгөв.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингээс бага байгаа тул "**Өөрчлөлтгүй**" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нягтлан бодогч, эд хариуцагч нар нь цагийн бүртгэлд бичигдээгүй, эрхлэгчийн шийдвэргүйгээр илүү цагийн мөнгө авсан, нягтлан бодогч нь балансын урамшууллыг эрхлэгчийн тушаалаас 2 сараар илүү тооцож авсан, албан томилолтын мөнгийг сургуулийн захирлын зөвшөөрлөөр хүүхдийн цэцэрлэгийн байгууллагаас авсан байна | 1 | 1482,5 | 1 | 1482,5 | | | | | | | | |
| Тус цэцэрлэгийн 2024 оны тооллогын бүртгэлд газрын хэмжээг 1мкв, нийт үнийг 6.030.9 гэж бүртгэсэн бөгөөд уг газар нь газар эзэмших эрхийн гэрчилгээнд 3618 мкв хэмжээтэй, үнэ нь 7.236.0 төгрөг байна. Биет бус хөрөнгийн данс болон газар эзэмших гэрчилгээнд байгаа хэмжээ зөрүүтэй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 42 нэр төрлийн 28.529.1 мянган төгрөгийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **3** | **1482,5** | **1** | **1482,5** | | | **2** | **0** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУПИТОР Ц.СОЮНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-24

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМБО АУДИТ" ХХК-НИЙ АУДИТОР Р.МЯДАГМАА

Огноо: 2025-02-19